



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2013 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.6-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газар /Б.Жаргал/-д үүрэг болгосугай.

3. “Авто зам, замын байгууламжийн барила, их засвар, шинэчлэлтийн ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Батзаяа/-д даалгасугай.



А.ГАНСҮХ

Зам, тээврийн сайдын 2013 оны
03 дугаар сарын 28 ны өдрийн
71 дугаар тушаалын хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА, ИХ ЗАСВАР,
ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ,
ЧАНАР БАЙДАЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлийн технологийн мөрдөлт, зураг төсөл, стандарт, норм дүрмийн хэрэгжилт, гүйцэтгэлийн чанар байдалд дүгнэлт өгөхөд оршино.

1.2. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлыг (Цаашид замын барилгын ажил гэх) улсын ашиглалтад оруулахын өмнө хийгдэх техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах, хэмжилт судалгаа хийх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах ажлыг “Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв” улсын төсөвт үйлдвэрийн газар, Зам, тээврийн яамны Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газартай хамтран зохион байгуулна.

1.4. Замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах ажлын хэсэг нь хэмжилт, судалгаа хийх шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан байна.


1.5. Хэмжилт, судалгааны үр дүнгээр замын барилгын ажлын гүйцэтгэлийн чанар, үндсэн хийц, хэсгүүд нь зураг төсөл, техникийн шаардлага болон бусад холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлно.

1.6. Замын барилгын ажилд хийгдсэн хэмжилт судалгааны ажлын тайлан нь техникийн үзүүлэлт, чанар байдлын дүгнэлт болно.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Шинээр ашиглалтад орж байгаа авто зам, замын байгууламж барилга, их засвар, шинэчлэлт хийгдсэн дараах ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргана.

2.1.1. Хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр үйлчлэх хүрээ нь олон улс, улсын болон орон нутгийн чанартай, технологийн нарийн горим бүхий авто зам, замын байгууламж;



2.1.2. Их засвар, шинэчлэлт хийгдсэн олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламж;

Гурав. Хэмжилтийн ажлын дараалал

3.1. Замын барилгын ажил нь зураг төсөл, техникийн шаардлагын дагуу бүрэн гүйцэд хийгдэж дууссан тохиолдолд гүйцэтгэгч болон зөвлөх компани /хяналтын инженер/ нь гүйцэтгэлийн эцсийн тайлан гаргаж, энэ тухай мэдэгдлийг Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газарт гаргана.

3.2. Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан энэ журмын 1.3-т зааснаар замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах, хэмжилт, судалгаа хийх хугацааг тогтоож, ажлын хэсгийг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилно.

3.3. Тухайн ажлын хэсэг нь ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах, хэмжилт, судалгааны ажлыг авто зам, замын байгууламжийн уртаас хамааран ажлын 3-5 хоногт хийж гүйцэтгэнэ.

3.4. Ажлын хэсэг нь авто зам, гүүрийн уртаас хамааран хэмжилт, судалгааны ажил дууссанаас хойш тайлангаа ажлын 3 хоногт багтаан боловсруулж Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газарт ирүүлэх бөгөөд ажлын тайланг үндэслэн комисс ажиллах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.


Дөрөв. Хэмжилт хийх ажлын чиг үүрэг

4.1. Шинээр ашиглалтад орох авто зам, замын байгууламжийн барилгын ажлын дараах үзүүлэлтэд хэмжилт хийж чанар байдалд дүгнэлт гаргана. Үүнд:

- 4.1.1. Замын хучилтын бат бэх байдалд;
- 4.1.2. Замын гадаргуугийн тэгш байдал;
- 4.1.3. Замын хучилтын зузаан, нягтарлын зэрэг;
- 4.1.4. Замын хучилтын барзгаржилт;
- 4.1.5. Замын далан суурийн даац; /DCP/
- 4.1.6. Замын хөвөөний нягт;
- 4.1.7. Замын геометр хэмжээсүүд;
- 4.1.8. Замын эргэц, өргөсгөлийн байдал;
- 4.1.9. Гүүр хоолой, хиймэл байгууламжийн хэмжээс ба чанар байдал /УББ 13-202-00/;
- 4.1.10. Замын тоноглол тэмдэгжүүлэлт;
- 4.1.11. Замын урт, координат.

4.2. Их засвар, шинэчлэлт хийгдсэн авто зам, замын байгууламжийн дараах үзүүлэлтэд хэмжилт хийж чанар байдалд дүгнэлт гаргана. Үүнд:

- 4.2.1. Замын гадаргуугийн тэгш байдал;
- 4.2.2. Авто замын хучилтын зузаан, нягтралын зэрэг;



- 4.2.3. Замын хучилтын барзгаржилт;
- 4.2.4. Замын хөвөөний нягт;
- 4.2.5. Замын геометр хэмжээсүүд;
- 4.2.6. Замын эргэц, өргөсгөлийн байдал;
- 4.2.7. Гүүр хоолой, хиймэл байгууламжийн хэмжээс ба чанар байдалд үнэлгээ өгөх /УББ 13-202-00/;
- 4.2.8. Замын тоноглол тэмдэгжүүлэлт;

4.3. Замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах хэмжилтийг тухайн замын нийт уртад 300 метр хүртэлх зай тутамд, замын эргэлт, өргөсгөлтэй хэсэг бүрт хийх ба хэрэв хэмжилтээр шаардлага хангаагүй гарсан бол түүний эзлэх уртыг олох зорилгоор хоёр тийш 20 метр тутамд хэмжилтүүдийг дахин хийнэ.

4.4. Замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах хээрийн хэмжилтийн ажлыг дулааны улиралд буюу “Авто замын уур амьсгал геотехникийн нөхцөл”-ийг удирдлага болгон дараах хугацаанд хийж дуусгасан байна.

4.4.1. IAIB бүсэд	7-р сарын 01-ээс	09-р сарын 01
4.4.2. IIA бүсэд	6-р сарын 01-ээс	09-р сарын 30
4.4.3. IIB бүсэд	6-р сарын 01-ээс	10-р сарын 01
4.4.4. IIIA бүсэд	4-р сарын 15-аас	09-р сарын 30
4.4.5. IIIB бүсэд	5-р сарын 01 -ээс	09-р сарын 30

Тав. Хэмжилт, судалгаа хийх үеийн техникийн аюулгүйн арга хэмжээ

5.1. Замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргахдаа юуны өмнө зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.1.1. Хэмжилтийн үед зам, тээврийн ослоос хамгаалж хэмжилт хийж буй ажилтнуудыг хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах;

5.1.2. Хэмжилтийн үед зөөврийн хамгаалалтын түмбэ ашиглах ба хэмжилтийн цэгээс хоёр тийш нь 25 метрийн зайтай байрлуулна;

5.1.3. Судалгаа, хэмжилтийн ажлыг өдрийн цагаар хийх ба гэгээ тасарсанаас хойш хийхийг хориглоно;

5.1.4. Замын далан, хучилтын өргөн, нүхэн болон торон хагарлын талбайг хэмжих зэрэг замын өргөнөөр хийгдэх судалгаа, хэмжилтийг гүйцэтгэх үед ажлын эхлэл, төгсгөлд дарцагтай хөдөлгөөн зохицуулагч нарыг ажиллуулна;

5.1.5. Хөдөлгөөний аль нэг зурваст судалгаа хэмжилт явуулахдаа замын голоор хөдөлгөөний өргөнийг тусгаарласан тэмдгийг 50 метр тутамд, нэг



чигийн хөдөлгөөн заасан тэмдгийг урсгалын эхэнд ажил эхлэх цэгээс 25 метр тутамд тавьсан байна;

5.1.6. Зарим онцлог хэсгүүдэд хэмжилт хийх үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын хажуугаар явуулахаар зохицуулж болно;

5.1.7. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах хэмжилт судалгааны ажлын үеийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

Зургаа. Хэмжилтийн үр дүнг боловсруулах

6.1. Замын барилгын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тогтоохдоо хэмжилт, тоон үзүүлэлтүүдийг тухайн замын техникийн шаардлагыг үндэслэн боловсруулна.

6.2. Хэрэв зарим хэмжилтийн үзүүлэлт нь техникийн шаардлагад заагаагүй тохиолдолд холбогдох хэмжилтийн аргачлал болон стандарт, норм дүрмийн дагуу хүлцэх хэмжээний хязгааруудыг авч хэрэглэнэ.

6.3. Шинээр ашиглалтад орж буй томоохон гүүрийг “Авто замын гүүрүүдэд үзлэг шалгалт хийж, ашиглалтын түвшин тодорхойлох болон цаашид авах арга хэмжээний төсөл боловсруулах заавар”-ийн дагуу хэмжилтийн ажлыг хийж, чанар байдалд дүгнэлт гаргана.

6.4. Хэмжилт, судалгааны ажлын дүнг нэгтгэж, техникийн шаардлага болон зураг төслийн үзүүлэлтүүдийг хангасан байдлаар нь хувь хэмжээг тогтоож, нэгтгэсэн хэлбэрээр уг журмын хавсралтын дагуу тайланг гаргана.


6.5. Тайланд хэмжилт судалгааны ажлыг хийхээр бүрэлдэхүүнийг томилсон шийдвэр, түүний ажлын даалгавар, талбайн хяналт хийж гүйцэтгэсэн хяналтын инженер болон зөвлөх, гүйцэтгэгч байгууллагын хүсэлт тавьсан албан бичиг, техникийн шаардлага, тайлбар бичиг, лабораторийн дүгнэлтүүд, хөндлөн огтлолын нэг маягийн зураг, муруйн хэсгүүдийн /эргэцтэй/ ажлын зургийн хуулбар болон бусад холбогдох баримт бичгийг хавсаргана.

6.6. Замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргах, тайланг 3 хувь үйлдэн гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

Долоо. Хүлээх хариуцлага

7.1. Замын барилгын ажлын техникийн үзүүлэлт, чанар байдалд дүгнэлт гаргасан байгууллага нь уг хэмжилт, судалгаа хийсэн тайлангийн үнэн зөв байдлыг хангахын зэрэгцээ өөрийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

--- о О о ---



Зам, тээврийн сайдын 2013 оны 71 дугаар
тушаалаар батлагдсан журмын нэгдүгээр
хавсралт

.....ЧИГЛЭЛИЙНКМ ЗАМЫН
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЧАНАР БАЙДЛЫН ДҮГНЭЛТ ГАРГАСАН ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮН

Он.....сар.....өдөр

№	Хэмжилтүүд	Хэмжих нэгж	Техникийн шаардлагад зааснаар	Техникийн үзүүлэлтийн хэмжилтээр	Техникийн шаардлагаар %/ хангасан хангаагүй		Тайлбар
					хангасан	хангаагүй	
1	Замын хучилтын бат бэх	мПа	220				
2	Замын хучилтын тэгш байдал	м/км	2-4.				
3	Хучилтын зузаан	см	>4.75				
	нягт	гр/см ³	>2.3				
4	Хучилтын гадаргуун барзгаржилт	мм	>0.5				
5	Далан суурийн далан	%	30				
	даац суурь	%	80				
6	Хөвөөний нягт	%	>98				
7	Хөндлөн хучилтын өргөн	м	>7				
	огтлолын хучилтын хэвгий	%	1.6-2.4				
	хөвөөний өргөн хэмжээс	м	>1.5				
8	Замын эргэлт	%	их				
	Эргэцийн өргөсгөл	м	их				
9	Хиймэл байгууламж	үзлэгээр	Зураг төсөлд заасан байдлаар				
10	Замын тоноглол, тэмдэгжүүлэлт	үзлэгээр	Зураг төсөлд заасан байдлаар				
11	Замын урт, координат	км-GPS	Зураг төсөлд заасан байдлаар				

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Галд Торжиг нарийн бичгийн даргаар
онд: 2013 дугаар тунгааг
77

Зам, тээврийн сайдын 2013 оны 71 дугаар
тушаалаар батлагдсан журмын хоёрдугаар
хавсралт

.....ЧИГЛЭЛИЙНКМ ЗАМЫН
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЧАНАР БАЙДЛЫН ДҮГНЭЛТ ГАРГАСАН ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮН

Он.....сар.....өдөр

№	Хэмжилтүүд	Хэмжих нэгж	Техникийн шаардлагад зааснаар	Техникийн үзүүлэлтийн хэмжилтээр	Техникийн шаардлагаар %/ хангасан хангаагүй		Тайлбар
					хангасан	хангаагүй	
1	Замын хучилтын тэгш байдал	м/км	2-4.				
2	Хучилтын зузаан	см	>4.75				
	Хучилтын нягт	гр/см ³	>2.3				
3	Хучилтын гадаргуун барзгаржилт	мм	>0.5				
4	Хөвөөний нягт	%	>98				
5	Хөндлөн хучилтын өргөн	м	>7				
	Огтлолын хучилтын хэвгий	%	1.6-2.4				
	Геометр хөвөөний өргөн хэмжээс	м	>1.5				
6	Замын эргэлт	%	Эргэцийн хэвгий	их			
			Эргэцийн өргөсгөл	их			
7	Хиймэл байгууламж	үзлэгээр	Зураг төсөлд заасан байдлаар				
8	Замын тоноглол, тэмдэгжүүлэлт	үзлэгээр	Зураг төсөлд заасан байдлаар				

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Галд Төрийн нарийн бичгийн дарга-аас
2013 оны 71 дугаар тушаал